

2023 он 01 сар 20 өдөр

Дугаар 23/01

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ард Кредит ХК-иас авсан зээлийн нөхцлийг өөрчлөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 болон 76.1.18 дах хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Ард Кредит ХК-иас авсан дараах гурван зээлийг жилийн 25 хувийн хүүтэй, 12 сарын хугацаатай 370.0 (гурван зуун далан) сая төгрөгийн нэг зээл болгон сунгасугай. Үүнд:
 - a. 2021 оны 7 дугаар сарын 01-нд жилийн 22 хувийн хүүтэй авсан 184,759,150.69 төгрөгийн зээл;
 - b. 2021 оны 7 дугаар сарын 30-нд жилийн 22 хувийн хүүтэй авсан 35,000,000 төгрөгийн зээл;
 - c. 2021 оны 8 дугаар сарын 02-нд жилийн 22 хувийн хүүтэй авсан 150,000,000 төгрөгийн зээл.
2. Өмнөх гурван зээлийн нийт барьцаа хөрөнгө болох нэгж бүр нь 10,000,000 (арван сая) төгрөгийн үнэ бүхий нийт 770,000,000 (долоон зуун далан сая) төгрөгийн Гацууртын бондыг Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн эзэмшиж буй нэгж бүр нь 852.19 (найман зуун тавин хоёр төгрөг арван есөн мөнгө) төгрөгийн үнэ бүхий 1,085,440 (нэг сая наян таван мянга дөрвөн зуун дөчин) ширхэг Ард Даатгал ХК-ийн хувьцаагаар сольсугай.
3. Сонирхлын зөрчилгүй буюу хараат бус гишүүд шийдвэр гаргасан болохыг дурдсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



П.БАТБАЯР

2023 он 2 сар 14 өдөр

Дугаар 23/02

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 46.6, 70 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, ТУЗ-ийн 2023 оны 2 сарын 14-ний өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх, хөрөнгө оруулалтын өгөөжөө ихэсгэх зорилгоор 2022 оны санхүүгийн жилд компанийн хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Компанийн тухай хуульд заасны дагуу ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн тухай үндэслэлийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



П.БАТБАЯР

2023 он 02 сар 15 өдөр

Дугаар 23/03

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал олгох тухай

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 4 сарын 17-ний өдрийн 20/11 тоот тогтоолоор баталсан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Цалин, Урамшууллын бодлого, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ТУЗ-ийн гишүүдийн ирц болон гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн тооцсон 2022 оны цалин, урамшууллыг “хавсралт 1”-ийн дагуу олгосугай.
2. ТУЗ-ийн цалин, урамшууллыг Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаагаар олгосугай.
3. Урамшууллаар олгосон хувьцааг 2 (хоёр) жилийн хугацаанд худалдахгүй байх нөхцөлтэй олгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Б.Шагж), Санхүү Эрхэлсэн захирал (Б.Золбоо), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод Аудитор (М.Мөнх-Эрдэнэ) нарт тус тус даалгасугай.


ДАРГА



П.БАТБАЯР

(1)

Board members	Status	Monthly compensation	Salary		Maximum possible		Performance %		Performance %		Total in MNT of Adj. P.
			Compulsory	Payment form	Attendance	Self-evaluation	Attendance	Self-evaluation			
% of annual compensation			50%		30%	20%					4,880
1. Batbayar P.	Chairman	6,000,000	36,000,000	Cash	21,600,000	14,400,000	100%	100%	21,600,000	14,400,000	36,000,000
2. Gdbayar O.	Committee chair	4,000,000	24,000,000	Cash	14,400,000	9,600,000	90%	100%	12,960,000	9,600,000	22,560,000
3. Munkbat Ch.	Committee chair	4,000,000	24,000,000	Cash	14,400,000	9,600,000	90%	89%	12,960,000	8,550,000	21,510,000
4. Arnaud Ventura	Committee chair	4,000,000	24,000,000	Cash	14,400,000	9,600,000	78%	69%	11,893,333	6,600,000	18,493,333
5. Mihail Zeldovich	Board member	3,000,000	18,000,000	AARD	10,800,000	7,200,000	92%	97%	10,200,000	6,975,000	17,175,000
6. Bruno Raschle	Board member	3,000,000	18,000,000	Cash	10,800,000	7,200,000	97%	100%	10,600,000	6,975,000	17,575,000
7. Ganhyrag Ch.	Board member	3,000,000	18,000,000	Cash	10,800,000	7,200,000	100%	83%	10,800,000	5,962,500	16,762,500
8. Sühdori A.	Board member	3,000,000	18,000,000	Cash	10,800,000	7,200,000	95%	92%	9,952,000	6,637,500	16,589,500
9. Sergelen M.	Board member	3,000,000	18,000,000	Cash	10,800,000	7,200,000	90%	97%	9,720,000	6,975,000	16,695,000
Total			198,000,000		118,800,000	79,200,000			110,685,333	72,675,000	183,360,333



Extraordinary board meeting 1
 Ordinary board meeting 4
 External voting decision 22
 Total 27

2023 он 03 сар 03 өдөр

Дугаар 23/04

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдэд хувь тэнцүүлсэн урамшуулал олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, компанийн дүрмийн 8.1.4 болон ТУЗ-ийн 2023 оны 3 сарын 3-ны өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн

ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь 2022 оны санхүүгийн жилд хувьцаа эзэмшигчдэдээ нэгж хувьцаанд 2 (хоёр) ширхэг АрдКойныг хувь тэнцүүлэн олгохыг зөвшөөрсүгэй.
2. Хувь тэнцүүлсэн урамшуулал авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Хувь тэнцүүлсэн урамшууллыг хувьцаа эзэмшигчдийн АрдКойны дансанд 2023 оны 4-р сарын 30-ны өдөр олгосугай.
4. Урамшууллаар олгосон АрдКойн 2 (хоёр) жилийн хугацаанд түгжээтэй байх ба жил бүр 5 дугаар сарын 1-нд 50%-иар захиран зарцуулах эрх нээгдэхийг дурдсугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэж, урамшуулал олгохыг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-д даалгасугай.
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор (М.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



П.БАТБАЯР

2023 он 03 сар 17 өдөр

Дугаар 23/05

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 3 сарын 17-ны өдрийн эчнээ санал хураалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2023 оны 4-р сарын 29-ний өдрийн 16:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар Дүүргийн, 8-р хороо, Бага тойруу 1, А.Амарын гудамж 2, Нийслэлийн Соёлын төв өргөөнд зарлан хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 4 сарын 7-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, хоёроос доошгүй өдөр түтмын сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2023 оны 3 сарын 22-ны өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2023 оны 4 сарын 11-ний өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, танилцуулга зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2023 оны 3 сарын 27-ны өдрийн дотор үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
6. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2023 оны 4 сарын 28-ны өдрийн 14:00 цагаар тасалбар болгосугай.
7. Хурлын даргаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн дарга П. Батбаярыг томилсугай.

2023 он 03 сар 17 өдөр

Дугаар 2365

Улаанбаатар хот

8. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.

Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн дарга П. Батбаяр

Хурал байгуулах комиссын гишүүд:

Гүйцэтгэх захирал Ч. Ганхуяг

Санхүү эрхэлсэн захирал Б. Золбоо

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б. Шагж

Хуульч Ө. Ашхүү

Маркетингийн ерөнхий менежер Б. Ганчимэг

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:

Б. Баттулга (Блүмсбюри Секьюритис ҮЦК ХХК)

Тооллогын комиссын гишүүд:

Г. Нандин-эрдэнэ (Блүмсбюри Секьюритис ҮЦК ХХК)

Г. Гүнбилиг (Блүмсбюри Секьюритис ҮЦК ХХК)


10. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэл захирал Ч.Ганхуягт даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



П.БАТБАЯР



**2023 ОНЫ 4 САРЫН 29-НИЙ ӨДӨР ХУРАЛДАХ
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
3. Компанийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах (саналын хуудас);
4. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
5. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох (саналын хуудас);
6. Компани өөрийн гаргасан хувьцааг зах зээлээс худалдан авах тухай (саналын хуудас);
7. ТУЗ-ийн төсвийг батлах тухай (саналын хуудас)

2023.03.17



**АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ЖК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №5)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2023 оны 4-р сарын 29-ны өдрийн 16:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар Дүүргийн, 8-р хороо, Бага тойруу 1, А.Амарын гудамж 2, Нийслэлийн Соёлын төв өргөөний зааланд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
Ердийн гишүүд		
1		
2		
3		
4		
5		
Хараат бус гишүүд		
1		
2		
3		
4		

5		
---	--	--

Санамж: Кумулятив аргаар ТУЗ-ийн гишүүдийг сонгоно. Таны эзэмшиж буй саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлж (Хувьцааны тоо * сонгогдох гишүүний тоо) таны санал өгөх эрхийг тооцно. Жишээ нь: Та 100 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг ба компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй гэвэл таны эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь нийт 900 (100*9гишүүн) саналын эрхтэй болно. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар саналын эрхээ хуваарилан өгөх эрхтэй.

Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна.


Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2023 оны ... -р сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____/...../

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:



**АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №3, 5, 6, 7)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2023 оны 4-р сарын 29-ны өдрийн 16:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар Дүүргийн, 8-р хороо, Бага тойруу 1, А.Амарын гудамж 2, Нийслэлийн Соёлын төв өргөөний зааланд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэрийн томьёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.			
2	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг санал хураалтын дүнгийн дагуу томилсугай.			
3	Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь өөрийн гаргасан хувьцааг зах зээлээс эргүүлэн худалдан авахыг зөвшөөрсүгэй.			
4	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсвийг "хавсралт 1"-ийн дагуу баталсугай.			

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч Үнэт цаасны компани (ҮЦК) дээр очин, хурлын материалтай танилцаж, санал авах хуудсаар саналаа өгнө.

3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичин, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэх нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
4. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудсыг хүчингүйд тооцно.
5. Саналыг саналын хуудсаар эсвэл цахимаар өгөх боломжтой.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2023 оны ... -р сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____/...../

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:



2023 оны 3 сарын 17-ны өдрийн
23/05 тоот тогтоолын 3-р хавсралт/

"АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА

ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 3 сарын 17-ны өдрийн 23/05 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах тухай зарлаж байна.

Компанийн оноосон нэр: Ард Санхүүгийн Нэгдэл ХК (AARD)

Хурал хуралдуулах газар: Улаанбаатар хот, Сүхбаатар Дүүргийн, 8-р хороо, Бага тойруу 1, А.Амарын гудамж 2, Нийслэлийн Соёлын төв өргөөнд

Огноо: 2023 оны 4 сарын 29-ний өдрийн 16:00 цагт

Санал өгөх хэлбэр: Ард Апп (Ard App) болон цаасаар саналаа өгнө.

2023 оны 4 сарын 29-ний өдөр хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид урьдчилсан санал өгөх боломжтой. Саналыг Ард Секюритиз ҮЦК ХХК компанийн Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 17 давхар хаягаар дамжуулан авах ба саналын хуудас хүлээн авах сүүлийн хугацааг 2023 оны 4 сарын 28-ний өдрийн 14:00 цагаар тасалбар болгоно.

Хурлын хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
3. Компанийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах (саналын хуудас);
4. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
5. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох (саналын хуудас);
6. Компани өөрийн гаргасан хувьцааг зах зээлээс худалдан авах тухай (саналын хуудас);
7. ТУЗ-ийн төсвийг батлах тухай (саналын хуудас)

Бүртгэлийн өдөр: 2023 оны 4 сарын 7-ны өдөр

Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. Компанийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар;

4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.

Хувьцаа эзэмшигч та 2023 оны 3 сарын 27-ны өдрөөс хойш ажлын өдрүүдэд ажлын цагаар өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандах, эсхүл www.ardholdings.com цахим хуудсаар зочлон хурлын материалтай танилцах боломжтой.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 17 давхар
Утас: 77078080

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



**АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ МАТЕРИАЛ**

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. Компанийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.

2023 он 03 сар 31 өдөр

Дугаар 25/06


Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТУЗ-ийн НБД-ыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай

Монгол Улсын хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.1, 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 3 сарын 31-ний өдрийн эчнээ санал хураалтын шийдвэр болон ажилтны гаргасан хүсэлтийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалыг хавсран гүйцэтгэж байгаа Батзориг овогтой Шагжийг 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. Ажлаас чөлөөлсөнтэй холбоотойгоор цалин урамшууллын тооцоо нийлэхийг Ерөнхий нягтлан бодогч (Г. Сэлэнгэ)-д, ажил хүлээлцэхийг хуульч (Ө. Ашхүү)-д тус тус үүрэг болгосугай.



П.БАТБАЯР

2023 он 03 сар 31 өдөр

Дугаар 23/07


Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Эрсдэл Эрхэлсэн Захирал томилох тухай

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дах хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 3 сарын 31-ний өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрдэнэбаатар овогтой Төртогтохын туршилтын хугацааг 2023 оны 2 сарын 28-ны өдрөөр дуусгавар болгож, 2023 оны 3 сарын 1-ний өдрөөс Эрсдэл эрхэлсэн захирлын албан тушаалт томилсугай.
2. Эрсдэл эрхэлсэн захирлын цалин, урамшууллыг “Хавсралт 1”-ийн дагуу тохирч, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-д даалгасугай.



ТУЗ-ийн 2023 оны 3 сарын 31-ний өдрийн

26/04 тоот тогтоолын "хавсралт 1"

1. The monthly salary of the Chief Risk Officer shall be specified per "table 1".

Name	Basic salary	Social security	Personal income tax	Net Salary
Turtogtoh E.	5,000,000	632,500	436,750	3,930,750

Table 1: Monthly salary

2. Regarding the specifics of the position, communication allowance shall be allowed up to MNT20,000 per month.
3. The remuneration shall be aligned with the directors' and officers' salary and remuneration policy.

2023 он 04 сар 26 өдөр

Дугаар 29/08

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны аудитлагдсан
тайлангийн дүгнэлтийг батлах тухай

~~Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх хэсэг, Төлөөлөн Удирдах~~
Зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны зөвлөмж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 4
сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Грант Торнтон Аудит ХХК-иас компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн авч, санхүүгийн тайланг баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцуулахыг Гүйцэтгэх захирал ("Ганхуяг")-д даалгасугай.



П. БАТБЯАР

2023 он 04 сар 26 өдөр

Дугаар 25/09


Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Гүйцэтгэх захирлын 2022 оны гүйцэтгэлийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хоргооны зөвлөмж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 4 сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гүйцэтгэх захирлын 2022 оны үндсэн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг 100% (нэг зуун хувь)-иар баталж, "Хавсралт 1"-ийн дагуу энгийн хувьцаа болон мөнгөн урамшуулал олгохыг зөвшөөрсүгэй
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү эрхэлсэн захирал (Б.Золбоо), Дотоод Аудит (Б.Мөнх-Эрдэмэ) нарт тус тус даалгасугай.



П. БАТБАЯР

2023 он 06 сар 07 өдөр

Дугаар 23/11

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Охин компани байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, компанийн дүрмийн 8.1.3' дахь хэсэг, ТУЗ-ийн 2023 оны 6 сарын 7-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Ардын тэтгэврийн данс ХХК-тай хамтран нэгж хувьцаа нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 1,000 ширхэг энгийн хувьцаатай ЭсСиПиЭмЭн оноосон нэртэй хязгаарлагдмал хариуцлагатай компанийг 60:40 харьцаагаар хөрөнгө оруулалт хийж, үүсгэн байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, хувьцаа эзэмшигчийг төлөөлж ЭсСиПиЭмЭн ХХК-ийг үүсгэн байгуулах хуралд оролцох, баримт бичигт гарын үсэг зурах, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, санал өгөх эрхийг ТУЗ-ийн даргад олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж холбогдох зардлыг компаниас гаргахыг Санхүү эрхэлсэн захирал (Б. Золбоо)-д, хяналт тавьж ажиллахыг Дотоод Аудитор (М.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА



П. БАТБАЯР

2023 он 06 сар 07 өдөр

Дугаар 23/12

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөх тухай

Компанийн тухай хуулийн 77, 80 дугаар зүйл, ТУЗ-ийн 2023 оны 6 сарын 7-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн дарга П. Батбаяр гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасантай холбоотойгоор 2023 оны 6 дугаар сарын 7-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. ТУЗ-ийн дарга чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор холбогдох хууль, дүрэм, журмын дагуу гишүүний цалин хөлс, урамшууллын тооцоо болон бусад тооцоог хийхийг Ерөнхий нягтлан бодогч (Г.Сэлэнгэ)-д зөвшөөрсүгэй.
3. ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг шалгаруулж, ТУЗ-ийн дараагийн ээлжит хурлаар танилцуулж, томилуулахыг Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо (О. Одбаяр)-нд даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллагад мэдэгдэхийг хуулийн зөвлөх (Ө. Ашхүү)-д, хяналт тавьж ажиллахыг Дотоод Аудитор (М.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА



П. БАТБАЯР

2023 он 06 сар 07 өдөр

Дугаар 23/13

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох,
Гүйцэтгэх захирал чөлөөлөх тухай

ТУЗ-ийн 2023 оны 6 сарын 7-ны өдрийн ээлжит бус хурлын 23/13 тоот тогтоол шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн даргаар Ч. Ганхуягийг сонгосугай.
2. ТУЗ-ийн даргаар Ч. Ганхуяг сонгогдсонтой холбоотойгоор Ч. Ганхуягийг Гүйцэтгэх захирлын албан тушаалаас чөлөөлсүгэй.
3. Гүйцэтгэх захирал чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, гэрээ болон холбогдох бусад хууль, дүрэм, журмын дагуу цалин хөлс, ээлжийн амралтын тооцоо болон бусад тооцоог хийхийг Ерөнхий нягтлан бодогч (Г.Сэлэнгэ)-д зөвшөөрсүгэй.

ДАРГ  О. ОДБАЯР

2023 он 06 сар 07 өдөр

Дугаар 23/14

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон
гүйцэтгэгч томилох тухай*

Компанийн тухай хуулийн 76.1.8, Хөдөлмөрийн тухай хуулийн 47.1, ТУЗ-ийн 2023 оны 6 сарын 7-ны өдрийн ээлжит бүс хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр компанийн санхүү эрхэлсэн захирал Б. Золбоог томилсугай.
2. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн ТУЗ-тэй байгуулах гэрээний нөхцөл, төслийг боловсруулан ТУЗ-д танилцуулж, батлуулахыг Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо (О. Одбаяр)-нд даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, Гүйцэтгэх захирлын өөрчлөлтийг эрх бүхий байгууллагад мэдэгдэх, бүртгүүлэхийг хуулийн зөвлөх (Ө.Ашхүү)-д, хяналт тавьж ажиллахыг Дотоод Аудитор (М.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГ  О. ОДБАЯР

2023 он 06 сар 29 өдөр

Дугаар 23/16

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Байгууллагын кредит карт нээлгүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйл 80.4 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 6 сарын 26-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК Худалдаа Хөгжлийн банкнаас 3,200,000 долларын бизнесийн зээл авахтай холбоотойгоор Худалдаа Хөгжлийн банкнаас гаргасан нөхцлийн хүрээнд 500,000,000 төгрөгийн эрхтэй байгууллагын кредит карт, зээлийн шугам нээлгүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж компанийг төлөөлж зээлийн гэрээ байгуулах, зээлтэй холбоотой шаардлагатай бусад шийдвэр гаргах эрхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч(Б.Золбоо)-д олгосугэй.



2023 он 06 сар 30 өдөр


Дугаар 23/17

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, 80 дугаар зүйл 80.4 дэххэсэг, "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК ("Компани")-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 6-р сарын 26-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компани нь Худалдаа Хөгжлийн банкнаас 3,200,000 (гурван сая хоёр зуун мянга) ам.долларын 60 сарын хугацаатай, жилийн 13.20%-ийн хүүтэй зээлийг Үл хөдлөх эд хөрөнгө худалдан авах зориулалтаар авахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү Худалдаа Хөгжлийн банкны зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Компанийн 4,993,900,000 (дөрвөн тэрбум есөн зуун ерэн гурван сая есөн зуун мянга) төгрөгтэй тэнцэх хэмжээний Ирээдүйд мөнгөн хэлбэрээр орж ирэх орлого, түүний үр шимийг барьцаалуулахыг зөвшөөрсүгэй.
3. Тогтоолын 1 дэх хэсэгт заасан зээлийн барьцаанд "Ард Пропертиз" ХХК-ийн өмчлөлийн дараах үл хөдлөх хөрөнгийг барьцаалах зөвшөөрлийг олгосугай:
 - 3.1.1. Y-2203024862 дугаартай Нийслэлийн Соёл амралтын хүрээлэн /14240/, Энхтайваны өргөн чөлөө 17 тоот барилгын 9 дүгээр давхар хаягт байрлах 1455.45 м.кв талбай бүхий Зочид буудлын зориулалттай үл хөдлөх хөрөнгө;
 - 3.1.2. Э-2203001536 улсын бүртгэлийн дугаартай 1462001158 нэгж талбарын хэмжээтэй, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 19-р хороо шарга морьт 4 гудамж 178 хаягт орших 699 м.кв талбай бүхий Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газрын гэрчилгээ, гэрээ, кадастрын зургийн хамт "Ард Пропертиз" ХХК-ийн нэр дээр шилжсэний дараа Худалдаа Хөгжлийн банканд нөхөж барьцаалуулах;
 - 3.1.3. Y-2203031212 дугаартай Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 19-р хороо, Шарга морьт 4 гудамж 178 тоот хаягт орших 477 м.кв талбай бүхий хувийн сууц, гаражын зориулалттай үл хөдлөх хөрөнгө;
4. Тогтоолын хэрэгжилтийг хангаж Худалдаа хөгжлийн банкны зээлийн гэрээ, барьцааны гэрээ, холбогдох бусад гэрээнд Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Золбоод олгосугай.



2023 он 06 сар 30 өдөр

Дугаар 23/18

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, 80 дугаар зүйл 80.4 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 6-р сарын 26-ны өдрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК ("Компани")-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компани нь Худалдаа, Хөгжлийн банкнаас 500,000,000 (таван зуун сая) төгрөгийн 24 сарын хугацаатай, худалдан авалтын гүйлгээнд жилийн 22.80 хувь, бэлэн мөнгө болон шилжүүлгийн гүйлгээнд жилийн 30.00 хувийн хүүтэй бизнес кредит картыг нээлгүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү Худалдаа, Хөгжлийн банкны зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар дараах барьцаа хөрөнгийн барьцаалсугай. Үүнд:
 - 2.1.1. Компанийн 650,000,000 (зургаан зуун тавин сая) төгрөгтэй тэнцэх хэмжээний Ирээдүйд мөнгөн хэлбэрээр орж ирэх орлого, түүний үр шимийг барьцаалуулах.
3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж Худалдаа, хөгжлийн банкнтай зээлийн гэрээ, барьцааны гэрээ, холбогдох гэрээг байгуулж, Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Золбоод олгосугай.



2023 он 7 сар 8 өдөр

Дугаар 23/19-1

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.17, компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 7 сарын 8-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн охин компани Ардын тэтгэврийн данс ХХК-ийн 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,010,000 ширхэг хувьцааг 100% буюу нийт 10,010,000,000 төгрөгөөр үнэлэн, хувьцаанд хамаарах бүх эрх үүргийн хамт Өндөрхаан ХК-д шилжүүлсүгэй;

2. Энэхүү тогтоолын 1.-д заасан санхүүжилтийг компани авлагаар бүртгэж, авлагаа Өндөрхаан ХК-ийн нэмж гаргах хувьцаагаар солих нөхцөлтэйгээр хаахыг даалгасугай.

3. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу санхүүжилтийг олгож, тогтоолын хэрэгжилтийг ханган, Өндөрхаан ХК-тай хувьцаа худалдах, худалдан авах гэрээ байгуулах, шаардлагатай бусад арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Золбоо)-д даалгасугай.



Ч.ГАНХУЯГ

2023 он 7 сар 8 өдөр

Дугаар 23/20

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа худалдан авах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл 76.1.18 дахь хэсэг, компанийн дүрмийн 8.1.3 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 7 сарын 8-ны өдрийн ээлжит хурлаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ардын тэтгэврийн данс ХХК-ийн хувьцаа эзэмшигч Н. Мөнхнасангийн тус компанид эзэмшиж байгаа нийт энгийн хувьцааны 5 хувь буюу 500,500 ширхэг хувьцааг, нэгж хувьцааг 5,994 төгрөг, нийт 2,999,997,000 (хоёр тэрбум есөн зуун ерэн есөн сая есөн зуун ерэн долоон мянган) төгрөгөөр худалдан авахыг зөвшөөрсүгэй.
2. Хувьцаа худалдах, худалдан авахтай холбоотой Ардын тэтгэврийн данс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол болон хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орсонтой холбоотой компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах хувьцаа эзэмшигчийн тогтоолд хувьцаа эзэмшигчийг төлөөлж ТУЗ-ийн дарга (Ч. Ганхуяг) гарын үсэг зурж, баталгаажуулсугай.
3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг төлөөлж Н. Мөнхнасантай хувьцаа худалдах, худалдан авах гэрээ болон компанийн эрх шилжүүлэх гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б. Золбоо)-д даалгасугай.



Ч. ГАНХУЯГ

2023 он 7 сар 8 өдөр

Дугаар 25/21

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчтэй
байгуулах гэрээний нөхцөл батлах тухай*

Компанийн тухай хуулийн 76.1.9 дэх хэсэг, 83.7 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 6 сарын 7-ны өдрийн 23/14 тоот тогтоол, 2023 оны 7 сарын 8-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б. Золбоотой байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшууллын хэмжээг тогтоолын Хавсралт 1-д зааснаар тогтоосугай.
2. Гэрээний үргэлжлэх хугацаан дахь Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн ажлын төлөвлөгөө, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг Хавсралт 2-т зааснаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, хууль тогтоомж, компанийн дүрэм журамд нийцүүлэн гэрээ байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ч. Ганхуяг)-д зөвшөөрсүгэй.



Ч. ГАНХУЯГ

2023 он 8 сар 25 өдөр

Дугаар 23/23

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцааны хяналтын багц худалдан авах санал гаргах тухай

Компанийн тухай хуулийн 56.2, 76.1, 80.4 дүгээр заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журам, ТУЗ-ийн 2023 оны 8 сарын 25-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь хөрөнгө оруулалтын зорилгоор Хөвсгөл ХК (HVL)-ийн нийт гаргасан энгийн хувьцаанаас 48,690 ширхэг буюу хяналтын багцыг худалдан авах саналыг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 03 сарын 20-ны 38 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам”-д заасны дагуу сайн дурын үндсэн дээр гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1.-д заасан хувьцааг сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргахтай холбоотой мэдэгдэлд санал болгож буй үнэ 84 төгрөг, худалдан авах саналын эхлэх хугацааг 2023-оны 8 дугаар сарын 28-ны өдөр, дуусах хугацааг 2023-оны 9 дүгээр сарын 29-ний өдөр, хувьцааны худалдан авах төлбөрийн хугацааг 2023 оны 10 дугаар сарын 2-ны өдөр тус тус байхаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж холбогдох арга хэмжээг авч, зардлыг компаниас гаргахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Б. Золбоо)-д, хяналт тавьж ажиллахыг Дотоод Аудитор (М.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.



Ч.ГАНХУЯГ

2023 он 9 сар 25 өдөр

Дугаар 23/24

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ажилд томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76.1.18, 82.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 47-49, 56, 64 дүгээр заалтууд, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хорооны зөвлөмжийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хянан нийцүүлэлт эрхэлсэн захирал / ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын хавсарсан албан тушаалд Эрдэнэбилэгийн Мандалмааг 2023 оны 9 сарын 25-ны өдрөөс эхлэн 3 сарын туршилтын хугацаатай томилсугай.
2. Э.Мандалмаад олгох үндсэн цалингийн хэмжээг Хавсралт 1-т заасны дагуу тогтоож, ажил үүргийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан сар бүр 20,000 (хорин мянган) төгрөгийн утасны төлбөрийг холбогдох журмын дагуу тооцохыг Нягтлан бодогч (Б. Долзодмаа)-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын дагуу ажилд томилогдон, гэрээ байгуулсаны урамшуулал болгон 10,000,000 (арван сая) төгрөгтэй тэнцэх Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа (50%) болон АрдКойн (50%) урамшууллыг Хөдөлмөрийн гэрээнд заасан нөхцөлөөр олгож, 3 сарын дараа гэрээ байгуулсан өдрийн ханшаар тооцон байршуулалт хийхийг Ерөнхий нягтлан бодогч (Г. Сэлэнгэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ч. ГАНХУЯГ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 9 сарын
25 өдрийн 23/24 тоот тогтоолын Хавсралт 1

Цалингийн хэмжээ

Овог нэр	Үндсэн цалин	НДШ	ХАОАТ	Гарт олгох цалин
Э.Мандалмаа	7,000,000	632,500	636,750	5,730,750



2023 он 10 сар 2 өдөр

Дугаар 24/25

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ


Ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, 79.3 дахь хэсэг, ажилтны хүсэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хянан нийцүүлэлт эрхэлсэн захирал/ТУЗ.НБД, Эрдэнэбилэгийн Мандалмаа нь ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул 2023 оны 10 сарын 02-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Ажлаас чөлөөлөгдөж буйтай холбогдуулж Э. Мандалмаад 2023 оны 10 сарын 02-ны дотор ажил үүрэг, эд зүйлсийг ажил хүлээлцэх актаар Хуулийн Ахлах Зөвлөх (Ө.Ашхүү) -д хүлээлцэхийг даалгасугай.

3. Ажилтантай Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, хөдөлмөрийн гэрээ болон холбогдох бусад хууль, дүрэм, журмын дагуу цалин хөлс, ээлжийн амралтын тооцоо болон бусад тооцоог хийхийг Ерөнхий нягтлан бодогч (Г.Сэлэнгэ)-д зөвшөөрсүгэй.



2023 он 10 сар 26 өдөр

Дугаар 23/26

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТУЗ-ийн гишүүн түр томилох тухай

Компанийн тухай хуулийн 77.5, 77.6, компанийн дүрмийн 8.3 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн ЗНДЦУ-ын хорооны зөвлөмж, ТУЗ-ийн 2023 оны 10 сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улсын иргэн Роланд Нэшийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нөхөн сонгууль хүртэл ТУЗ-ийн гишүүнээр түр томилсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх, бүртгүүлэх ажлыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.



2023 он 10 сар 26 өдөр

Дугаар 26/27

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Охин компанийн ТУЗ сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7, компанийн дүрмийн 8.1.3 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн ЗНДЦУ-ын хорооны зөвлөмж, ТУЗ-ийн 2023 оны 10 сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн охин компани болох Ард Пропертиз ХХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 5 гишүүнтэй байхаар өөрчлөлт оруулж, ТУЗ-ийн гишүүн Ө.Ашхүүг гишүүнээс чөлөөлж, Б.Золбоо, Г.Уянга, Ч.Ганхуяг (РД: ЦБ73112011), Г.Сэлэнгэ (РД: ЖМ86040667), Г.Билгүүн (РД: МЮ92021016) нарыг гишүүнээр сонгосугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүнийг улсын бүртгэлийн байгууллагад хуульд заасан хугацаанд бүртгүүлэхийг Ард Пропертиз ХХК-ийн Гүйцэтгэх захирал (Г.Уянга)-д даалгасугай.



2023 он 10 сар 26 өдөр

Дугаар 23/28

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ард Лизинг ХХК-д хөрөнгө шилжүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.17, компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 сарын 26-ны өдрийн ээлжит хурлаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК 18 тэрбум хүртэлх төгрөгийн үнэлгээ бүхий эдийн бус хөрөнгийг өөрийн охин компани Ардлизинг ХХК-д шилжүүлсүгэй.
2. Энэхүү тогтоолд заасан санхүүжилтийг компани хөрөнгө оруулалтаар бүртгэж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгийг шилжүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б. Золбоо)-д даалгасугай.



Ч.ГАНХУЯГ

2023 он 10 сар 26 өдөр

Дугаар 25/29

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*"Kingsway FCI Co-Investment SPC" санд
хөрөнгө оруулах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Хөрөнгө оруулалт, эрсдлийн хорооны зөвлөмж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК "Kingsway FCI Co-Investment SPC" санд 100,000 долларын хөрөнгө оруулалт хийхийг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ хэлцэлд компанийг төлөөлж гарын үсэг зурах, хөрөнгө оруулалт баталгаажснаас хойш эрсдэлийг тооцон зайлшгүй нөхцөлд хойшлуулшгүй арга хэмжээ авч ажиллахыг тус тус Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б. Золбоо)-д даалгасугай.

ДАРГА  Ч.ГАНХУЯГ

2023 он 10 сар 26 өдөр


Дугаар 23/30

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Хөрөнгө оруулалт, эрсдэлийн хороо, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 сарын 26-ны өдрийн ээлжит хурлаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөрөнгийн зах зээл, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан компани Ард секюритиз УЦК, Ард лизинг ХХК, Ардын тэтгэврийн данс ХХК, Ард бит ХХК нараас хувьцаагаа эргүүлэн худалдан авах шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллагад хүргэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б. Золбоо)-д даалгасугай.



2023 он 10 сар 26 өдөр

Дугаар 23/31

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Стратеги төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, ТУЗ-ийн 2023 оны 10 сарын 26-ны өдрийн ээлжит хурлаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2024-2026 оны стратеги төлөвлөгөө (OGSM)-г тогтоолын Хавсралт 1-ээр баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, компанийн үйл ажиллагааны төсөв төлөвлөгөөг баталж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захиралд тус тус үүрэг болгосугай.



2023 он 11 сар 09 өдөр

Дугаар 23/32


Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хөрөнгө шилжүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.17, компанийн дүрэм, Хөрөнгө оруулалт, эрсдлийн хорооны зөвлөмж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 сарын 09-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн дараах хөрөнгүүдээр Хөвсгөл ХК-ийг хөрөнгөжүүлсүгэй. Үүнд:
 - Кripto Үндэстэн ХК-ийн 5.7 хувийн хувьцааг шилжүүлэх үеийн зах зээлийн ханшаар тооцон шилжүүлэх,
 - Монгол Шуудан ХК-ийн 9.5 хувийн хувьцааг шилжүүлэх үеийн зах зээлийн ханшаар тооцон шилжүүлэх,
 - Даац Инвестмент ХХК-ийн 50.9 хувийн хувьцааг өртгөөр нь шилжүүлэх.
2. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн охин компаниудын дараах хөрөнгүүдээр Хөвсгөл ХК-ийг хөрөнгөжүүлсүгэй. Үүнд:
 - Тэнгэрлиг Медиа Групп ХК-ийн 22.8 хувийн хувьцааг шилжүүлэх үеийн зах зээлийн ханшаар тооцон шилжүүлэх,
 - ГрэйпСити Монголиа ХХК-ийн 45.0 хувийн хувьцааг өртгөөр нь шилжүүлэх.
3. Энэхүү тогтоолд заасан санхүүжилтийг компани авлагаар бүртгэж, авлагаа Хөвсгөл ХК-ийн нэмж гаргах хувьцаагаар солих нөхцөлтэйгөөр бүртгэхийг даалгасугай.
4. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу санхүүжилтийг олгож, тогтоолын хэрэгжилтийг ханган, Хөвсгөл ХК-тай холбогдох гэрээ хэлцэл байгуулах, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б. Золбоо)-д даалгасугай.



2023 он 11 сар 09 өдөр

Дугаар 23/33


Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Батлан даалт гаргах тухай

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 сарын 09-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Актив ХЗХ-ноос Тэнгэр Системс ХХК 2.5 тэрбум төгрөгийн зээл авахад батлан даалт гаргахыг Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, компанийг төлөөлж батлан даалтын гэрээ байгуулах, батлан даалттай холбоотой бусад шийдвэр гаргах эрхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Золбоо)-д олгосугай.



2023 он 11 сар 09 өдөр

Дугаар 23/34

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Батлан даалт гаргах тухай

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 сарын 09-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Актив ХЗХ-ноос Монголиан Нэйшнл Эквити Траст ХХК 2.5 тэрбум төгрөгийн зээл авахад батлан даалт гаргахыг Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, компанийг төлөөлж батлан даалтын гэрээ байгуулах, батлан даалттай холбоотой бусад шийдвэр гаргах эрхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Золбоо)-д олгосугай.



2023 он 11 сар 09 өдөр

Дугаар 23/35

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Батлан даалт гаргах тухай

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 сарын 09-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Актив ХЗХ-ноос Ард Финтек Солюшн ХХК 2.5 тэрбум төгрөгийн зээл авахад батлан даалт гаргахыг Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, компанийг төлөөлж батлан даалтын гэрээ байгуулах, батлан даалттай холбоотой бүсэд шийдвэр гаргах эрхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Золбоо)-д олгосугай.



2023 он 11 сар 09 өдөр

Дугаар 23/36


Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Батлан даалт гаргах тухай

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 сарын 09-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Актив ХЗХ-ноос Акела Секюрити ХХК 2.5 тэрбум төгрөгийн зээл авахад батлан даалт гаргахыг Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, компанийг төлөөлж батлан даалтын гэрээ байгуулах, батлан даалттай холбоотой бусад шийдвэр гаргах эрхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Золбоо)-д олгосугай.



2023 он 11 сар 09 өдөр

Дугаар 23/37

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Батлан даалт гаргах тухай

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 сарын 09-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Актив ХЗХ-ноос Ард Суппорт ХХК 2.5 тэрбум төгрөгийн зээл авахад батлан даалт гаргахыг Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, компанийг төлөөлж батлан даалтын гэрээ байгуулах, батлан даалттай холбоотой бусад шийдвэр гаргах эрхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Золбоо)-д олгосугай.



2023 он 11 сар 24 өдөр

Дугаар 23/38

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцааны хяналтын багц худалдан авах санал гаргах тухай

Компанийн тухай хуулийн 56.1, 56.2, 76.1.18, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22.1.1, Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журам болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 сарын 23-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь нэгдмэл сонирхолтой этгээдүүдтэй хамтран хөрөнгө оруулалтын зорилгоор Өндөрхаан ХК (ОНН)-ийн нийт гаргасан энгийн хувьцаанаас 49,900 ширхэг (44.6 хувь) хувьцааг худалдан авах саналыг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 03 сарын 20-ны 38 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам”-д заасны дагуу сайн дурын үндсэн дээр гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-д заасан Өндөрхаан ХК-ийн 49,900 ширхэг хувьцаанаас компани 36,472 ширхэг (32.6 хувь) хувьцааг худалдан авах санал гаргах бөгөөд компанийн нэгдмэл сонирхолтой бусад этгээдүүдийн саналыг нэгтгэн компани эрх бүхий этгээдэд хууль, журмын дагуу мэдээлэхийг дурдсугай.
3. Сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргахтай холбоотой мэдэгдэлд санал болгож буй үнэ 10,660 төгрөг, худалдан авах саналын эхлэх хугацааг 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр, дуусах хугацааг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр, хувьцааны худалдан авах төлбөрийн хугацааг 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр тус тус байхаар баталсугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж холбогдох арга хэмжээг авч, зардлыг компаниас гаргахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Б. Золбоо)-д, хяналт тавьж ажиллахыг Дотоод Аудитор (М.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.



2023 он 11 сар 24 өдөр

Дугаар 23/39

Улаанбаатар хот


ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Охин компанийн хувь нийлүүлсэн
хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх тухай*

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 62.1.16, 76.1.18 дахь заалт, Компанийн дүрмийн 8.1.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 сарын 23-ны өдрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Секюритиз ҮЦК ХХК-ийн нэгж хувьцааны нэрлэсэн үнэ болох 1,000 төгрөгийг 1,750 төгрөг болгон нэмэгдүүлсүгэй.
2. Ард Секюритиз ҮЦК ХХК-ийн хувьцааны нэрлэсэн үнийг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг компанийн өмнөх онуудын хуримтлагдсан ашгийн эх үүсвэрээс 1,501,467,000 (нэг тэрбум таван зуун нэг сая дөрвөн зуун жаран долоон мянган) төгрөгөөр нэмэгдүүлж нийт 3,503,423,000 /гурван тэрбум таван зуун гурван сая дөрвөн зуун хорин гурван мянган/ төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болгон өөрчилсүгэй.
3. Ард Секюритиз ҮЦК ХХК нь уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авах нөхцөл шаардлагыг хангах зорилгоор компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж байгаа болохыг дурдсугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, Ард Секюритиз ҮЦК ХХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн хуралд оролцох, хурлын шийдвэр, холбогдох баримт бичигт хувьцаа эзэмшигчийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Золбоо)-д олгосугай.

ДАРГА



ТАНХУЯГ

2023 он 12 сар 14 өдөр

Дугаар 23/41

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хөрөнгө шилжүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.17, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 сарын 14-ний өдрийн ээлжит хурлаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2023 оны 11 сарын 9-ний өдрийн 23/32 тоот ТУЗ-ийн тогтоолыг хүчингүй болгосугай.
2. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн дараах хөрөнгүүдээр Хөвсгөл ХК-ийг хөрөнгөжүүлсүгэй. Үүнд:
 - Крипто Үндэстэн ХК-ийн 5,854 ширхэг (5.7 хувь) хувьцааг шилжүүлэх үеийн зах зээлийн ханшаар тооцон шилжүүлэх,
 - Даац Инвестмент ХХК-ийн 15,333,001 ширхэг (51 хувь) хувьцааг өртгөөр нь шилжүүлэх,
3. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн холбоотой этгээдүүдийн дараах хөрөнгүүдээр Хөвсгөл ХК-ийг хөрөнгөжүүлсүгэй. Үүнд:
 - Гэр интерьер дизайн ХХК-ийн 1,000 ширхэг (100 хувь) хувьцааг өртгөөр нь шилжүүлэх,
 - ГрэйпСити Монголиа ХХК-ийн 450 ширхэг (45.0 хувь) хувьцааг өртгөөр нь шилжүүлэх.
4. Энэхүү тогтоолд заасан санхүүжилтийг компани авлагаар бүртгэж, авлагаа Хөвсгөл ХК-ийн нэмж гаргах хувьцаагаар солих нөхцөлтэйгөөр бүртгэхийг даалгасугай.
5. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу санхүүжилтийг олгож, тогтоолын хэрэгжилтийг ханган, Хөвсгөл ХК-тай холбогдох гэрээ хэлцэл байгуулах, шаардлагатай бүсэд арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б. Золбоо)-д даалгасугай.



2023.12.14

№ ^{23/}41-1

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Санхүүжилт олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.2 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Ард Санхүүгийн Нэгдэл ХК (наашид “Компани” гэх)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Хөвсгөл ХК-ийг хөрөнгөжүүлэх, үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Компаниас 17,036,000,000 (арван долоон тэрбум гучин зургаан сая) төгрөг хүртэлх хэмжээний санхүүжилтийг 1 жилийн хугацаатайгаар эргэн төлөх нөхцөлтэйгээр авах хэлцэл хийх зөвшөөрлийг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Золбоод **ОЛГОСУГАЙ**.
2. Санхүүжилтийн эргэн төлөлтийн хуваарь, зээлийн хөрөнгийг шилжүүлэх нарийвчилсан нөхцөл журмыг Хөвсгөл ХК-тай тохиролцож, холбогдох гэрээ, хэлцэл байгуулахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Золбоод **ДААЛГАСУГАЙ**.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 12 сарын 14-ний өдрийн 23/41 дугаартой тогтоолын 2, 3,4 дэх хэсгүүдийг тус тус хүчин төгөлдөр бусад **ТООЦСУГАЙ**.



Ч.ГАНХУЯГ

2023 он 12 сар 14 өдөр

Дугаар 23/42

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

МОСТ Финтек ХХК-д хөрөнгө оруулах сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, компанийн дүрмийн холбогдох заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 сарын 14-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. МОСТ Финтек ХХК-ийн IPO-д 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөгөөр хөрөнгө оруулалт хийхийг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү түгтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Б.Золбоо)-д даалгасугай.



2023 он 12 сар 14 өдөр

Дугаар 23/43

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Компанийн 2024 оны төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.18 болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 сарын 14-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2024 оны төсвийг тогтоолын Хавсралт 1-ээр баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Б.Золбоо) болон Санхүү эрхэлсэн захирал (Х.Билгүүн) нарт үүрэг болгосугай.

